Эрүүл Мэндийн Газар Хяналт Шинжилгээ Үнэлгээ
Мэдээлэлийн Хэлтэсээс бэлтгэн гаргав

Мэдээ хянасан
ХШҮМ*Х-ийн дарга Д.Наранмичид*

Мэдээ нэгтгэсэн
Мэргэжилтэн *Т.Уганжаргал*

Утас : 70562096
Вэб сайт:mohs.khe.gov.mn

Хэнтий аймгийн Засаг даргын дэргэдэх
Хэрэгжүүлэгч агентлаг
Эрүүл Мэндийн Газар

ЭРҮҮЛ МЭНДИЙН СТАТИСТИКИЙН МЭДЭЭЛЭЛ
2023 ОНЫ 3 САР

Чингис хот

Эх, хүүхдийн эрүүл мэнд
/2023 оны 3 сарын байдлаар/

Төрөлт

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар нийт 328 эх төрсөн ба өнгөрсөн оны мөн үеэс 55 төрөлтөөр буюу 16,7 хувиар өссөн байна. Аймгийн нэгдсэн эмнэлэгт 75,6% /248/ нь сумдаас ирж төрсөн байна.
Кесар хагалгаагаар төрсөн /82/ 25,0 хувийг эзэлж байна

Хүүхдийн эрүүл мэнд

2023 оны 3 сард Аймгийн хэмжээнд 332 хүүхэд амьд төрсөн нь өнгөрсөн оны мөн үеэс 55 хүүхдээр буюу 16.5 хувиар өссөн байна. Нийт амьд төрсөн хүүхдийн 160 буюу 48,1 хувь нь эрэгтэй, 172 буюу 51.9 хувь нь эмэгтэй байна. Амьд төрсөн хүүхдийн 3.6/12/ хувь нь бага жинтэй буюу 2500 гр-аас доош жинтэй төржээ. Төрөөд 1 цагийн дотор хөхөө амласан хүүхдийн эзлэх хувь 98,1 байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл

Аймгийн хэмжээнд 2023 оны 3 сард нялхасын эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 15,1 байна. Улсын дундаж 13,8
5 хүртэлх насны эндэгдэл 5 тохиолдол бүртгэгдсэн ба 1000 амьд төрөлтөд 15,1 байгаа нь өмнөх оны түвшинд байна. Улсын дундаж 16,4 промил байна.

Нялхас болон 5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан

5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг шалтгаанаар нь авч үзвэл: Нярайн амьсгалын гачаал-2, нярайн тархины хямрал-1, хатгалгаа-1, тархины цус харвалт-1 тус тус бүртгэгдсэн байна.

Жирэмсний хяналт

Жирэмсэний хяналтанд шинээр 360 жирэмсэн эмэгтэйчүүд хамрагдсан ба 92,5 хувь нь эхний 3 сартайд, 6,3 хувь нь 4-6 сартайд, 7 дээш сартайд 1,2 хувь нь хяналтанд орсон байна. Хяналтанд орсон жирэмсэн эмэгтэйчүүдийн 96,9 хувь нь цусны шинжилгээнд хамрагдсан ба цус багадалттай жирэмсэн 3 бүртгэгдсэн байна.
Шинээр хяналтанд хамрагдсан жирэмсэн эмэгтэйчүүдээс трихомониаз илрүүлэх шинжилгээнд 274 буюу 76,1 хувь нь эерэг-1, заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 274 буюу 76,1 хувь, тэмбүү илрүүлэх шинжилгээнд 357 буюу 99,1хувь, эерэг-2, ХДХВ/ДОХ илрүүлэх шинжилгээнд 357 буюу 99,1 хувь тус тус хамрагдсан байна.

Нас баралтын үзүүлэлтүүд

2023 оны эхний 3 сарын байдлаар нийт нас баралтын 91 тохиолдол бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үеэс 8 тохиолдлоор буурсан байна. 57 буюу 62,6 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Нас баралтын түвшин 1000 хүн амд 1,1 байна.

Нийт нас баралтын /38/41,8 хувь нь эмнэлэгт нас барсан бөгөөд үүнээс /13/34,2 хувийг хоног болоогүй нас баралт эзэлж байна.. 8-24 цагийн дотор 5 тохиолдол бүртгэгдсэн байна.

Хорт хавдрын шалтгаант нас баралт нийт нас баралтын /24/ 26,3 хувийг эзэлж байна.

Осол гэмтэл, гадны шалтгаант нас баралтын 19 тохиолдол бүртгэгдэж, нийт нас баралтын 25,7 хувийг эзэлж байна. Амиа хорлосон-3, бусдад хорлогдсон 1 тохиолдол, зам тээврийн осол-6, бусад осол-9 тус тус бүртгэгдсэн байна. 10000 хүн амд ногдох осол гэмтэл, гадны шалтгаант нас баралт 2,3 байна.

2023 оны эхний 3 сарын байдлаар артери гипертензийн эрт илрүүлэг үзлэгт нийт 7004 хүн хамрагдаж 60,4 хувь нь эмэгтэй байна. Үр дүнгийн үзүүлэлтээр онош батлагдсан 63 байна. Чихрийн шижингээр онош батлагдсан 12 тохиолдол байна.
Хөхний эрт илрүүлэг үзлэгт 2300 хүн хамрагдаж, умайн хүзүүний хорт хавдрын эрт илрүүлэгт 399 хүн хамрагдсан байна.

Амбулатори ,стационарын тусламж үйлчилгээний зарим үзүүлэлтүүд

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар эмнэлэгт 5547 хүн хэвтэн эмчлүүлж нийт 42040 ор хоног ашигласан бөгөөд дундаж ор хоног 7,0 байна.

Амбулаторит 2023 оны эхний 3 сарын байдлаар 86487 үзлэг хийгдсэний 14,9 хувийг урьдчилан сэргийлэх үзлэг, 67,5 хувийг өвчний учир амбулаторит, 10,4 хувийг идэвхитэй хяналтын үзлэг, үлдэх 7,2 хувийг гэрийн идэвхитэй болон дуудлагын үзлэг эзэлж байна.

Халдварт бус өвчлөл 31918 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеийнхээс 8513 өвчлөлөөр өссөн үзүүлэлттэй байна.

2023 оны 3 сарын байдлаар Осол гэмтлийн өвчлөлийн нийт 366 тохиолдол бүртгэгдсэнээс /242/66,1 эрэгтэй, /124/33,9 эмэгтэй байна. Осол гэмтлийн тэргүүлэх 5 шалтгаанд: бүх төрлийн уналт /125/34,1%, зам тээврийн осол /67/18,3%, амьгүй механик хүчин өртөх /66/18,2%, хүчирхийлэл /40/ 10,9% түлэгдэлт /31/ 8,5%, тус тус эзэлж байна.

Аймгийн хэмжээнд 2023 оны 3 сарын байдлаар 5676 түргэн тусламжийн дуудлага хүлээн авч гүйцэтгэснээс 17,6% нь алсын дуудлага эзэлж байгаа нь өмнөх оноос 3,0 хувиар буурсан байна. Осол гэмтлийн 111 дуудлага бүртгэгдсэн байна.

ХАЛДВАРТ ӨВЧИН

Аймгийн хэмжээнд 2023 оны эхний 3 сарын байдлаар 104 халдварт өвчний тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 13,1 ногдож байна. /Улсын дундаж 18,4/
Улс аймгийн дундажаас доогуур үзүүлэлттэй байна.

10000 хүн амд ногдох халдварт өвчин
2023 оны эхний 3 сарын байдлаар

Халдварт өвчин бүтэц

Нийт халдварт дотор Салхинцэцэг /52/ 50,0 хувь, БЗДХ /27/ 25,9 хувь, сүрьеэ /18/ 13,4 хувь, цусан суулга /3/2,9 хувь, ковид-1 1,5 хувь тус тус бүртгэгдсэн байна.

БЗДХ-ын 27 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 3,4 байна.
БЗДХ-ын дотор т эмбүү /7/, гонококкт халдвар /10/, трихомониз /10/, тохиолдол бүртгэгдэж урьд оноос 4 тохиолдлоор өссөн үзүүлэлттэй байна.